

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, Баасан гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 7-20

-
- 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 7-11
- 2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 10 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 11-13
- 3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 13
- 4.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/* 13-14
- 5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 14-16
- 6.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай/* 16-20

***Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 24-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор:

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Т.Мөнхцэцэг, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Д.Хашчулуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 10 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11
Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2

Бүгд: 12
63.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Г.Тэмүүлэн: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байгааг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав

Дөрөв.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын хэлтсийн дарга Б.Тэлмүүн, “Монгол газар тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн ТӨХХК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Газрын тосны хайгуул ашиглалтын газрын ахлах О.Түмэн-Өлзий нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын хэлтсийн дарга Б.Тэлмүүн хариулж, тайлбар хийв.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12

66.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний аудитын газрын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батбямба, мөн газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул байлцав.

Танилцуулгыг Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан хуралдаж эхэлсэн тул уг асуудлыг хэлэлцэхгүй болохыг мэдэгдэв./11:19 /

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 59 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
10 цаг 20 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Ганибалын Амартүвшин гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Засгийн газар 4 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хоёрдугаарт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Гурав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Дөрөвдүгээрт, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг.

Тавдугаарт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл. Төрийн аудитын байгууллагын орон тооны хязгаартай холбоотой асуудал байна.

Долоодугаарт, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 17 хууль, 1 тогтоол гэсэн ийм 7 асуудал байна.

Үүнтэй холбоотой саналтай гишүүд байна уу хэлэлцэх асуудалтай холбоотой?

Алга байна.хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд оруулцаая. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн зүйл бүрээр нь санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Би нэг зүйлийг тодруулаад
Хүрэлбаатар сайдаас тодруулж
асуугаадахъя.

Манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тодорхой санал, зөвлөмжүүдийг хүргүүлсэн байгаад байгаа. Үүнтэй холбогдуулаад Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл болоод 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүд дээр тодорхой өөрчлөлтүүдийг оруулъя гээд тэр дундаа нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 31 их наяд гэснийг 31.3 их наяд гэснийг 29.4 их наяд, эргээд гол үндсэн асуудал маань бол ерөөсөө нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлтэй холбоотойгоор одоо өргөн баригдсан нь бол 1.9 их наядын алдагдалтай орж ирэхээр бол орж ирсэн. Үүнийг 0 хувьтай болгох буюу эргээд нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хэмжээг 3.9 их наяд гэснийг бол 2 их наяд болгоё гэсэн ийм саналыг бол оруулж ирсэн байгаад байгаа юм.

Тэгэхээр энэтэй холбогдуулаад бол бид нар ирэх 2025 оноос эхлээд нэгдсэн төсвийн маань тэнцэл өөрөө сайжрах, илүү алдагдалгүй төсөв батлах ийм боломж, бололцоо бол бүрдэхээр байна гэсэн ийм саналтай бол байгаад байгаа. Тэгээд энэ дээр бид хэрэв Засгийн газар, манай Эдийн засаг, хөгжлийн яам маань ямар байр суурьтай байгаа бол? Энэ дээр та бүхэн бас байр сууриа илэрхийлээч. Хэрэв боломжтой гэж үзвэл энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргаад бол ирэх оны төсвийг тэнцвэржүүлсэн тэнцлийг бол 0 хувьтай байлгахар бол оруулъя гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал бол байгаад байгаа юм.

Хүрэлбаатар сайдын микрофоныг өгье.

Ч.Хүрэлбаатар: Төсвийн байнгын хорооны дарга болон Төсвийн байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тодорхой саналууд ирүүлсэн байна. Энэ саналыг бид нар хүндэтгэж үзэж байгаа. Гэхдээ би нэг зүйлийг бас Төсвийн байнгын хорооныхоо гишүүддээ хандаж хэлмээр байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг Эдийн засаг, хөгжлийн яам анх удаагаа боловсруулж, оруулж ирж байгаа юм. Анх удаагаа. Тэгээд энийг боловсруулахад Эдийн засаг, хөгжлийн яам мэдээж Сангийн яамтайгаа нэлээн хамтарч нэлээд ажиллаж байгаад оруулж ирсэн.

Тийм учраас би энэ дээр яг Засгийн газрын боловсруулсан байдлаар нь батлаад өгөөч энэ анхны удаа орж ирж байгаа учраас гэж л би хүсэлт тавимаар байна. Өөрөөр хэлбэл, өргөснөөр нь батлаад өгвөл их зүгээр байна. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл бол нөгөө төсвийн орлогодоо хоёр орлогыг бас тооцоогүй байгаа учраас яг энэ төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг харж макро эдийн засгийн прогноз хийж явах нь өөрөө бас их өрөөсгөл шүү. Хоёр гол орлогоо оруулаагүй байдаг учраас энийг бас нэлээд эргэж ер нь жоохон бодолцох ёстой зүйл юм байгаа юм гэдгийг хэлээд би анх удаагаа оруулж ирсэн юм байна. Яг үүгээр батлаад үзээч. Хэрвээ энэ гарахгүй бол дараа бас та бүгд маань нэлээд анхаарч үзнэ биз дээ.

Ер нь 24 оны төсвийн гүйцэтгэлийг аваад үзэх юм бол орлого даваад л ороод л явж байгаа өмнөх жилүүдээсээ, урьд төлөв баталснаасаа илүү орлого ороод л явж байгаа 24 онд. Тийм учраас энэ яг ор Засгийн газрын өргөн мэдүүлснээр нь л батлаад өгөөч л гэдэг зүйлийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Хүрэлбаатар сайдын байр суурийг бас ойлголоо.

Тэгэхээр бид нар бас ер нь энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл маань бол анх удаагаа бүсчилсэн хөгжилтэй холбогдуулж,

бүсчилсэн тогтолцоотой холбогдуулж бас орж ирж байгаа асуудлууд байгаа. Энэ дээр ойлголоо. Тэгээд дараа дараагийн асуудлууд дээр та хэд маань бас анхаарч үзэцгээгээрэй гэсэн саналыг хэлье дээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд төсвийн хүрээний мэдэгдэл болоод төсвийн төсөөллийн тухай хуультай холбогдуулаад тэгье. Ингээд зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь батлах, эцэслэн батлах зарчмын саналыг оруулж байна.

Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүний микрофоныг дахиж шинээр нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Төсвийн хүрээний мэдэгдэл орж ирж байна. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл жилдээ энэ чинь дунд хугацааны хөтөлбөр шүү дээ. Энэтэй ямарваа нэгэн байдлаар хөдөлгөөн орохгүй хэдэн жил мөрдөж явах ёстой. Тэгээд зарим жил 3 удаа хөдөлгөөн орсон л доо. Яагаад хөдөлгөөн ороод ирсэн юм бэ гэхээр эх захгүй нүүрсний хулгай, төмөр замын хулгай, янз янзын тэр хулгайнуудаас болоод энэ хулгай нь дэндчихсэн учраас нөгөө орлогын дутагдал гарч ирээд, тэр орлогын дутагдлаас болоод төсвийн хүрээний мэдэгдлээ хэд хэдэн удаа өөрчилсөн ийм тохиолдол байгаад байгаа юм л даа.

Тэгээд би нүүрсний хулгайд замбараагүй байсан л даа. Жилд 30-хан сая тонн нүүрс гардаг 2021 онд, 22 онд. Гэтэл 2023 онд нүүрсний хулгайтай тэмцэний үр дүнд 70 сая тонн нүүрс болсон, уул уурхайн бирж ажиллаж эхэлснээр аман дээрээс нь 60 доллароор зарж байсан нүүрсээ 179 доллароор, одоо 184 доллароор зарж байна. Яг тэр аман дээрээс нь 60 доллароор зарж байхад 2, 3

жилийн туршид дунджаар 400 доллар байсан шүү дээ. Тэгээд энэ их хулгайг бүгдээрээ хийгээд байсан учраас энэ төсвийн хүрээний мэдэгдлийн дагуу орлого нь орж ирэхгүй, орлого нь орж ирэхгүй учраас, дээрээс нь нөгөө Их Хурлын гишүүдийн яамдын сайд нарын учиргүй их шуналын үүднээс маш их хөрөнгө оруулалт, маш их гарын салаагаар урссан зардлыг нэмэгдүүлсний үндсэн дээр л энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ингэж их олон өөрчилсөн.

Тэгэхээр энэ жил дахиад энэ төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдөнө. Тэгээд 8 сард өөрчлөгдөнө гэж би яг харж байна. 8 сард өөрчлөгдөнө, 11 сард өөрчлөгдөнө. 2 удаа өөрчлөгдөнө, дахиад энэ 3 удаа хийх байхгүй юу.

Яагаад гэвэл энэ 24 оны төсөв яг цэвэр 2024 оны сонгуульд зориулсан төсөв болсон. Жалгын нэг хөрөнгө оруулалтуудыг тавьсан, замбараагүй хөрөнгө оруулалт тавьсан. Яамдын сайд нарын гарынхаа салаагаар урсдаг тэр хөрөнгө учир зүггүй болсон. Энд тэндгүй төрийн албан хаагч нар аялдаг, зугаалдаг, семинарддаг, сэм найрддаг энэ зүйл бүгдээрээ хэрээс хэтэрсэн. Энэ бүх зүйлийн чинь зардал хэтэрсэн учраас энэ шинэ парламент бүрдээд, Засгийн газар бүрдсэний үндсэн дээр энэ төсвийн тодотгол хийгдэнэ гэж би харж байгаа.

Тэгээд дахиад 2025 оны төсөв хэлэлцэхдээ дахиад төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчилж байгаад л, дахиад л орлогоо өндөр тавьж байгаад л зардлаа өсгөөд л ингээд төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг өөрчилнө гэж би харж байгаа. Тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авах вэ? Цаашидаа яаж ажиллах юм, яаж хариуцлагатай байх юм?

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Энд Төсвийн тухай хуульд өөрчлөлт ороод

хоёр том зарчмын өөрчлөлт орчихсон юм. Энийг тэр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулахыг Тэмүүлэн нарын гишүүд санаачилсан. Хоёр том өөрчлөлт. Нэг нь Төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төсөөллийг Эдийн засаг, хөгжлийн яам боловсруулдаг болсон. Энэ хоёр дахь том өөрчлөлт нь саяын таны хэлээд байгаа шиг төсөв өргөхдөө төсвийн хүрээний мэдэгдлийг, энэ төсөөллийг өөрчилдгийг хуулиар хорьчихсон. Тэгэхээр одоо энэ батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөөллийн дагуу төсөв орж ирнэ.

Өөрөөр хэлбэл, хуучин ингэж Их Хуралд баахан ажил хийдэг хэлэлцээж хэлэлцээж юм баталдаг. Тэгээд тэр нь ямар ч ач холбогдолгүй. Дараа нь төсөв өргөхдөө өргөн мэдүүлчихдэг ийм хариуцлагагүй гэх юм уу, замбараагүй байдлыг тэр өмнө нь оруулсан Тэмүүлэн нарын гишүүдийн санаачилсан хуулиар энэ алга болчихсон.

Тийм учраас энэ төсвийн төлөвлөлт, төсвийг төсөөллийг төсөв зохиохыг маш хариуцлагатай болгож өгсөн ийм зүйл байгаа юм гэдгийг би хэлмээр байна.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ яг энэ Тэмүүлэн гишүүний баталсан, өргөн барьсан энэ хуулиудаар яг энэ заалтуудыг хязгаарлах ийм хуулийн заалтуудыг баталж өгсөн л дөө. Тэгэхдээ энэ өөрөөр хэлбэл энэ чинь органик хууль адилхан л. Гэтэл дахиад энэ Төсвийн хууль чинь бас дахиад адил органик хуульгүй байхгүй юу даа. Тийм учраас яг энэ адилхан хүчин чадалтай учраас тэрийг нь шууд зөрчөөд л ороод ирдэг ийм тохиолдлууд зөндөө байна шүү дээ. Урьд нь ч гэсэн бас яг энэ төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй гэсэн заалтууд зөндөө л байж байсан. Тэгээд тэрийгээ дахиад л зөрчөөд ороод ирдэг байсан шүү дээ. Тэгээд энэ юм энэ чинь

тэгээд тийм яг тэр дарга нарын замбараагүй зардал гаргах тэр хүсэл, шунал дээр ерөөсөө л энэ төрийн хууль энэ тэр чинь бүгдээрээ хэтэрхий дорд орчихоод байна л даа. Тийм учраас энийг анхааруулж хэлж байгаа юм. Мэдээж энэ яг Тэмүүлэн нарын өргөн барьсан тэр хуулиа дагаад явчих юм бол сайн л байна. Тэгэх юм бол илүү төсвийн төсөөлөл сайн, зардал нь тодорхой орлого нь.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн санал хэллээ.

1 дүгээр зүйлтэй холбогдуулаад саналтай гишүүд байна уу?

Алга байна. Ингээд 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгийг эхний үе шаттай нэгтгэн батлах эцэслэн батлах саналыг гаргаж байна. Санал хураалт.

Эхний ээлжид энэ тест санал хураачихъя бид нар эхний. Уучлаарай нээрээ шинэ төхөөрөмж байгаа учраас яаж дарахаа манайхан мэдэхгүй байж магадгүй. Эхлээд хуруугаа хийх юм байна, тэгэнгүүт зөвшөөрсөн, татгалзсан гэж гарч ирэх юм байна. Энийг дахиад тест хийгээдэхье. Сая би урьдчилж шинэ төхөөрөмж дээр ажиллаж чадсангүй. Эхлээд хуруугаа хийнэ шинэ төхөөрөмж байгаа учраас хуруугаа хийнгүүт зөвшөөрсөн, татгалзсан гээд дэлгэц дээр 2 кноп гарч ирэх юм байна. Тэгэнгүүт зөвшөөрсөн, татгалзсан дэлгэц дээрээ дарах юм байна.

Дахиад тест хийгээдэхье. Тест санал хураалт дахиад явуулаадахъя. Манайхан эхлээд хуруугаа хийнэ, тэгээд хуруугаа аваад зөвшөөрсөн, татгалзсан гээд зөвшөөрсөн гээд дарна болж байна. За болж байна тээ? Одоо санал хураалт явуулъя.

Анхны хэлэлцүүлгийг эхний үе шаттай нэгтгэн эцэслэн батлах саналыг

дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд.

70 хувиар дэмжигдлээ.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн байна уу?

Амартүвшин гишүүн танилцуулах уу? Сандагаа гишүүн танилцуулъя. Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орцгооё.

10.42 цаг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Өмнөх асуудалд орж ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд талархаж байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төсөл 1 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүд байна уу?

Сангийн яамныхныг оруулж ирээрэй. Над дээр 1 асуулт байгаа 1 дүгээр зүйл дээр.

Ажлын хэсгийг танилцуулъя. Сандагийн Магнайсүрэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхамсүрэнгийн Баярмандал Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Болдбаатарын

Анхбаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Даваагийн Алтанцэцэг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн гүйцэтгэх захирал, Уранбаатарын Чинзориг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компанийн Гэрээ, эрх зүй газрын дарга, Очирпүрэвийн Түмэн-Өлзий Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компанийн Газрын тосны хайгуул, ашиглалтын газрын ахлах мэргэжилтэн, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга нар байна.

Тэлмүүн дарга орж ирсэн үү? Сангийн яамнаас хүн байна уу? Сангийн яамнаас хүн байна уу? Тодруулж асуух асуулт байгаад байгаа. Сангийн яамны газрын дарга Тэлмүүн байна уу? Сангийн яам орж иртэл энэ асуудлыг түр хойшлуулах уу? Дараагийнх нь хэлэлцээд явчихъя. Сангийн яамны газрын дарга Тэлмүүнийг дуудаж оруулж ирээрэй. Дараагийн асуудлаа хэлэлцээд явж байя.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиа хамт өргөн мэдүүлсэн 5 хууль, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг та бүхэнд хийе.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа хуулийн гол төслийн зорилго нь Төсвийн тогтвортой байдлын албаны төрийн албаны статус болон зөвлөлийн дарга, гишүүдийн албан тушаалын зэрэглэл, зэрэг, эрх зүйн байдлыг нарийвчлан тогтоох, үйл ажиллагааны баталгаа болон баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад бол чиглэгдэж байгаа.

Ингээд төсвийн тогтвортой байдлыг хангуулах, төсвийн холбогдох, дүн шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж

гаргах үүрэг бүхий орон тооны 7 гишүүний бүрэлдэхүүнтэй зөвлөл Улсын Их Хурлаас томилогдсон. Одоогоор Зөвлөлийн төрийн албаны статус болон зөвлөлийн дарга, гишүүдийн албан тушаалын зэрэглэл тодорхойгүй учраас Улсын Их Хурлаас томилогддог зөвлөл, хороо ижил түвшний төрийн байгууллагуудтайгаа адилтгаж төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах төрийн албаны төрийн албан тушаалтны зэрэглэлийн захиргааны адилтгах албан тушаалд хамааруулах юм.

Иймд Зөвлөлийн дарга, гишүүний эрх зүйн байдал, үйл ажиллагааны болон нийгмийн баталгааны асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нарийвчлан хуульчилж өгөх бодит хэрэгцээ, шаардлага бий болсон байна.

Ингэснээр зөвлөлийн үйл ажиллагаа бие даасан, хараат бус, ил тод, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэхээр байгаад байна.

Хуулийн төслийг *d.parliament.mn* дээр бас холбогдох хуулийн хугацааны дагуу бол байршуулсан байгаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д тусгасан өнөөгийн үндсэн дээр гэснийг нэрлэсэн үндсэн дээр гэж өөрчилсөн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийг боловсруулж байх үед 2010 онд Монгол Улс бага орлоготой, ядуу буурай орны тоонд багтаж, олон улс банк, санхүүгийн байгууллагаас бага хүүтэй, урт хугацаатай зээл авдаг байсан үед өрийг өнөөгийн үнэ цэнээр буюу өгөөжөөр нь хорогдуулан тооцоход тохиромжтой байсан.

Харин өнөөгийн байдлаар Монгол Улс дунджаас дээгүүр орлоготой орны тоонд багтах болж, арилжааны нөхцөлтэй зээл авдаг болсон тул өрийг өнөөгийн үндсэн дээр хорогдуулан

тооцох бус нэрлэсэн үнэ цэнээр тооцохыг олон улсын байгууллага төрийн байгууллагаас удаа дараа зөвлөсний дагуу нэрлэсэн үнэ цэн бүрдэх хугацааг 2025 оноос хэрэгжихээр хуулийн төсөлд тусгасан байна.

Ингээд хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг та бүхэнд тараасан байгаад байгаа.

Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Санал хураалтыг явуулъя.

Тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн 5 хууль, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Тестийн санал хураалт. 2 гишүүн нэмж орж ирсэн учраас шинэ төхөөрөмж байгаа. Эхний тест санал хураалт. Эхлээд хуруугаа хийцгээнэ. Даваасүрэн гишүүн хараарай. Булгантуяа гишүүн эхлээд хуруугаа хийнэ. Дахиад болсонгүй. Дахиад санал хураалтыг явуулъя. Эхлээд тест санал хураалт шүү. Тест санал хураалт, бүртгэлийн санал хураалт. Тэгье, эхлээд хуруугаа хийнэ. Ремүүв пингер /remove finger/ гэхээр аваад. Гарч ирэхгүй байна. Зөвшөөрсөн, татгалзсан гэж гарч ирэхгүй байна шүү.

Дахиад тест санал хураалтыг явуулъя. Дахиад бүртгэлийн санал хураалт. Ремүүв пингер /remove finger/ шинэ төхөөрөмж учраас нэг л жигдрэхгүй байна даа. Дахиад үзээдэхье. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн дахиад санал хураалт. Гарахгүй байна шүү дээ.

Илээр санал хураачих уу? Гараар хураахаар чинь горимын санал гаргая даа тээ? Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Одоо настай хүн гэхэд манай Баделхан гуай, Даваасүрэн гишүүн хоёрыг яая гэхэд бусад нь энэ юун дээр ажиллаж чадахгүй юм даа. Тэгээд энэ гараар хураах санал хураалт явахгүй бол шинэ машин дээр болохгүй байна. Тийм учраас гараар хураалгах саналыг дэмжиж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Гараар хураах горим саналыг. Шинэ төхөөрөмж байгаа учраас угаасаа болохгүй байна. Манай техникийн албаныхан төхөөрөмжөө жигдрүүлээрэй.

Илээр санал хураалт явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

10-оос 10 уу?

12-оос 10 гишүүн дэмжиж илээр санал хураалтыг явуулахыг дэмжлээ.

Саяын санал хураалтыг явуулъя.

Хуулийн төслийг хэлэлцэхийг, үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

12-оос 9 үү? Тоолоорой. 12-оос Пүрэвдорж гишүүн.

12-оос 9. Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их

Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ингээд хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орвол оръё. Сангийн яам ирсэн үү?

10.49 цаг

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хууль хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбартай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Булгаа гишүүн, Булгантуяа гишүүн танилцуулна.

Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

10.50 цаг

Дараагийнх нь “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 10 гишүүн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс хууль хоорондын нийцлийг хангах үүднээс “Засгийн газарт чиглэл өгөх тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан батлуулах нь зүйтэй гэсэн санал дэмжигдсэн байгаа байгаад байгаа.

Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсанг та бүхэнд тараасан байгаа. Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасгай.

1.1.Улсын Их Хурлаас 2005 оны 3 дугаар сарын 18-ны өдөр баталсан Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуульд нийцүүлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

1.2.Монгол Улс мөн 1996 онд нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдаа худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээрийн нэгийн хавсралтын бараа худалдааны тухай олон талт хэлэлцээрүүдийн сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүн тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн Си-д заасантай нийцүүлэн Улсын Их Хурлаас 2008 онд баталсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан

төсөлтэй хамтатган 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Энэхүү 2024 оны 10 дугаар сар нь зөв үү? Төсөл төсөв өргөн баригдах чинь 1 сар шүү дээ, 9 сар шүү дээ.

10 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгасгай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал хураалт явуулъя. Санал хураалтыг явуулъя.

Тогтоолын төслийг хэлэлцэхийг нь дэмжье гэсэн асуудлаар санал хураалтыг явуулъя. Гараар. 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9

12-оос 9-өөр дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг миний бие танилцуулчихъя даа. Би өөрөө танилцуулчихъя.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

10.53 цаг

Түрүүн хойшлуулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуультай холбоотой, газрын тос боловсруулах үйлдвэртэй холбоотой Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг түрүүн танилцуулсан байгаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төсөл 1 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Миний хувьд асуух асуулт байна. Энэ дээр Тэлмэн дарга байгаа тээ Сангийн яам?

Энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн үндсэн үзэл баримтлал нь ерөөсөө энэ газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуульд заасан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулах бүтээгдэхүүн авах зарчимд үндэслэх гол зохицуулалт бол байгаад байгаа.

Тэгэхээр би Сангийн яамнаас гол асуух гээд байгаа зүйл нь Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль 2028 онд бол хүчингүй болохоор бол Улсын Их Хурал баталсан. Тэгэхээр энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль цаашид хэрэгжих үү? Энэ хэрэгжих боломжтой юу? Энэ дээр ямар байр суурь байгаа бол? Үндэслээд үзэл баримтлалаа хийсэн хууль нь өөрөө 28 онд хүчингүй болох гээд байдаг. Тэгэхээр одоо оруулж ирж байгаа энэ хуулийн өөрчлөлт маань бол цаашид яаж хэрэгжих вэ гэдгийн гол асуудал байгаа.

Сангийн яам хариулъя. 3 номер.

Б.Тэлмүүн: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн.

Яг энэ хуулийн төслийг томъёолж, Засгийн газар дээр томъёолоход энэ асуудал нэлээн ярьсан юм. Тэгээд газрын тосыг Газрын тосны хуулиар зөвхөн бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр ашигладаг. Өөр хэлбэрээр ашигладаггүй. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5.2-т Засгийн газартай байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглах гэдэг ийм түр хуулиар ийм түр хуулийн боломжийг олгосон. Энэ хууль хэрэгжих хугацаа буюу энэ түр хугацаанд газрын тос, хайгуул ашиглалтын үйл ажиллагаа явуулахад бүтээгдэхүүн хуваах гэрээтэй адилхан татварын орчин мөрдөе гэдэг ийм асуудал яригдсан.

Бидний хувьд Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж дуусах үед яг энэнтэй холбогдсон цогц харилцааг зохицуулах Газрын тосны хуулийн нэлээн том өөрчлөлт орох ёстой юм байна лээ. Тэр үед энэ асуудал дахиж яригдана. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хууль хүчингүй болсноороо энэ Засгийн газар гэрээний үндсэн дээр байгуулсан энэ харилцаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын харилцаа бас шууд хүчингүй болчихно гэж үзэхгүй байгаа. Энэ гэрээний харилцаа үргэлжлээд л явна.

Тэгэхдээ энэ асуудлыг бид нар 28 онд заавал дахиж ярих шаардлагатай болно. Зөвхөн татвар гэхгүй энэ цогц харилцааг. Ийм байдлаар хуулийн төслийг ярилцаж оруулж ирсэн.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Хууль хэдий 28 онд хүчингүй болох ч гэсэн Газрын тосны шинэчилсэн найруулгын төсөл орж ирэхэд бол бас яригдаж, шинэчлэгдээд явагдах ёстой асуудал юм байна л гэсэн үг байна шүү дээ тээ. Тэгэхээр газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эд тосоор найдвартай хангахтай холбогдуулж эрэл хайгуулыг дэмжих энэ зохицуулалт

цаашид үргэлжлэх юм байна л гэж ойлгоорой. Баярлалаа танд.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

1 санал гаргахаар Байнгын хорооноос бид нар бэлдсэн байгаа. Энэ хугацаатай холбоотой байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гээд.

Үүгээр зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Гараа өргөөрэй. Гараа өргөж байгаарай. 4,5, 6, 7, 8 уу?

12-оос 8 байна. 12-оос 8-аар дэмжигдлээ.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулчихъя.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудалдаа орцгооё.

10.57 цаг

“Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Үндэсний аудитын газраас хийнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Танилцуулгыг Үндэсний Аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг танилцуулна. Наранчимэг дарга микрофонд урьж байна. 3 номер.

Ц.Наранчимэг: Эрхэм хүндэт байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага жилд дунджаар 4900 орчим аудитыг гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрт давхардсан тоогоор 12 мянган байгууллага хамрагдаж байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт заасан цаглаврын дагуу санхүүгийн аудитад зарцуулж буй хугацааг сүүлийн 3 жилийн дунджаар үзэхэд санхүүгийн аудитыг 2.2 хүн өдөрт зарцуулж байгаа нь хэт богино хугацаа бөгөөд энэ нь аудитын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Мөн хүний нөөцийн дутмаг байдлаас шалтгаалж цаг хугацаандаа аудит хийдэггүй аудитын эрсдэл өндөр байгаад байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар жилд дунджаар 90-130 автомашины байгууламж, гүүр, зам, завсрын ажлууд болон концессын 2-3 ажилд аудит хийж, дүгнэлт өгөх зэрэг аудитыг хийж гүйцэтгэж байна.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн зэрэг аудитыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээгээр гүйцэтгэлийн аудитад зайлиггүй мэргэжсэн инженер, төсөв санхүүгийн тусгайлсан мэргэжилтэн, хүний нөөц, олон улсын чанартай гэрээ, хэлцэл, төсөл, хөтөлбөрт ажиллах хууль, эрх зүйн олон улсын хуульч, эрх зүйч, шинжээч зайлиггүй шаардлагатай байгааг Төрийн аудитын тухай хуулийн дагуу зөвлөх шинжээчээр авч ажиллуулж байна.

Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацааны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийхэд орон нутагт төрийн аудитын байгууллагын босоо тогтолцоот орон нутагт байгаа төрийн аудитын байгууллага маань 10-12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа нь тухайн орон нутагт аудит хийхэд одоо хүндрэлтэй байгаа юм.

Иймд бид төрийн аудитын байгууллагын орон тоог зайлиггүй нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харгалзан үзэж орон тооны дээд хязгаарыг 130 албан хаагчаар нэмэгдүүлэхээр саналыг Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн болно.

Та бүхэн анхаарал тавьсанд баярлалаа. Шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Энэ ингээд төсвийн жилийн дундуур бүтэц, орон тоо нэмэх, төсөв нэмэх асуудал ингэж орж ирж болох юм уу? Хэзээнээс гэж байгаа юм цаг хугацаагаа? Аудиторрууд ачаалалтай ажиллаж байгаа нь үнэн. Хүн хүч дутмаг байдаг нь үнэн юм билээ. Ер нь маш их ачаалалтай. Хамгийн гол нь энэ их цаг хугацаа, хүн хүч орсон аудитын дүгнэлт, зөвлөмжийг харамсалтай нь төрийн байгууллагууд, төрийн өмчийн компаниуд ажил болгох, зөвлөмж, дүгнэлтийг, актыг биелүүлэх энэ тал дээр ер нь бас хангалтгүй л байна л даа. Тэгээд л жил болгон гардаг нөгөө зөрчил дутагдлууд гарсаар л байгаа. Тэгээд нийтдээ 130 хүний орон тоог нэмэх гэж байгаа юм байна шүү дээ. Энэний эдийн засгийн тооцоогоо гарга даа, цалин мөнгө нь хэд байх юм? Хаана хаана энэ 130 орон тоонууд байх

юм? Нийслэл дээр байх юм уу, аймгууд дээрээ байх юм уу? Тэгээд энэ хүмүүс чинь аудитораар ажиллах улсууд нь байгаа юм уу, цалин нь ямар хэмжээтэй байх юм? Нийт төсөв хэдэн төгрөг зарцуулагдахаар байгаа юм, хэзээнээс гэж байгаа юм гээд энэ дээр тодорхой хариулт өгөөдхөөч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр яг хэзээнээс энэ төсөв юу гэдэг юм байгууллага чинь орон тооны дээд хязгаар 626 болох гэж байгаа нь хэрэгжиж эхлэх гээд байгаа юм? Төсөв батлагдсантай холбогдуулж төсөв батлагдсан байгаад байгаа юм. Тэгэхээр төсвийн жил эхэлчихсэн байхад болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу гэдэг асуудлыг асууж байх шиг байна. Хэзээнээс хэрэгжих энэ асуудлыг Нарантуяа дарга 3 номер.

Ц.Наранчимэг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Бид энэ орон тоог нэмэгдэхэд 53.3 тэрбум төгрөг шаардлагатай. Тэгэхдээ бид төсөвтэй багтаагаад 3 үе шаттайгаар энийг орон тоогоо нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа. Нэг мөсөн 130 орон тоо нэмэгдэхгүй нэгдүгээр асуудал нь.

Хоёрдугаар асуудал нь аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудынхаа орон тоог эхний ээлжид нэмэгдүүлнэ гэж зорьж байгаа. Жишээлбэл, нэг аймагт дунджаар 8-12 орон тоотой байгаа. Нийтдээ аудит хийх байгууллагын тоо маань аймагт 228 байгууллагаас дээш байгууллагад аудит хийж байгаа.

Дээрээс нь гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудит хийж байгаа учраас орон нутаг руугаа түлхүү орон тоогоо нэмэгдүүлнэ гэсэн ийм бодлоготой ажиллаж байгаа. Тэгээд үе шаттайгаар төсөвтөө багтаагаад, 3

жилийн хугацаанд гэсэн эхний байдлаар бид төлөвлөлтөө гаргасан. 2024 онд төсөвтөө багтаагаад тодорхой хэмжээг 25 оны төсөв дээрээ бас тодорхой хэмжээний орон тоонуудыг нэмэгдүүлнэ. Ерөнхийдөө орон нутаг руугаа хандуулах ийм бодлоготой байгаад байгаа.

Төрийн аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Төсвийн байнгын хорооны дарга маань санаачлаад Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулж өгсөн. Энэ орсон өөрчлөлтөөр бид төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг 30 хоногийн дотор төлөвлөгөө гаргаж ирүүлээд, хэрэгжүүлээгүй бол ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авахаар ийм хуулийн зохицуулалтыг Төсвийн байнгын хорооноос гаргаж өгсөн нь бид нарын ажилд бас маш чухал үүрэг рольтой байгаа.

Тийм учир бас яг 30 хоногтоо байгууллагууд маань аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын төлөвлөгөөг ирүүлж байна. Дахиад хэрэгжилтийг нь хянахад хэрэгжүүлээгүй бол төрийн аудитын байгууллагаас ажлаас чөлөөлөх ийм албан шаардлагыг хэрэгжүүлэх учраас дараа жилийн бид нарын тайлан дээр илүү үр дүнтэй энэ ажил маань хэрэгжээд төсөв захирагч маань илүү хариуцлагатай болж эхэлж байгаа. Энэ бол та бүхэнд бас талархаж байгаа. Төсвийн байнгын хорооны хамт олонд бас талархаж байгаа, гишүүддээ маш их талархаж байгаа аудитын байгууллагаас.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр яг энэ оноос нэмэгдэх орон тоо нэмэгдээд байх, төсөв нэмэгдээд байх юм байхгүй шүү дээ. Төсөв батлагдчихсан байгаа шүү дээ тээ? Тэгэхээр энэ зүгээр ерөөсөө дээд хязгаар үйл ажиллагааны төлөвлөгөө ирэх 3, 4 жилийн хугацаанд та нэмэгдүүлж болох дээд хязгаар юм байна л гэсэн үг юм байна шүү дээ төсөвтөө

нийцүүлээд? Тэрийг протоколдоо хэл дээ. Батлагдсан төсөвтэй юм уу? 3 номер.

Ц.Наранчимэг: Энэ онд бас төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалин 6 дугаар сарын 1-нээс нэмэгдэж байгаа. Бид ямар ч байсан өөрсдөө аудит хийдэг байгууллага бас үлгэр жишээч байх ёстой учраас төсөвт хүндрэл учруулахгүйгээр яг төсөвтөө багтаагаад 2025 оны төсөвт дахиад аудитын байгууллага хэд байх нь вэ гэсэн ийм тооцооллуудыг гаргасан байгаа учраас 626 маань дээд хязгаар, нэмэгдүүлэхээ бол 3 жилтэй гэсэн ийм тооцооллыг хийсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Үгүй ээ би яг асуугаад байгаа нь энэ ондоо нэмэгдэж, орон тоо чинь нэмэгдэх юм байхгүй ээ. Төсөв чинь батлагдчихсан 24 онд тийм биз? 3 номер ойлголцлоо.

Сандагаа гишүүн нэмж тодруулах уу? Асуучих Сандагаа гишүүн. Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Тэгээд энийг ингээд чуулган дуусах гээд ингээд баахан гишүүд ер нь ажил ихтэй байгаа үе гээд далимдуулаад л ингээд л баахан орон тоо, төсөв нэмэгдэж оруулж ирэх гээд байна даа? Энэ чинь 53 тэрбум төгрөгийн асуудал ярьж байна шүү дээ. Тэгээд төрийн алба чинь бас 130 орон тоогоор ингээд 1 байгууллага дээр гэхэд л нэмэгдэх асуудал ярьж байна. Тэгээд энийг Сангийн яам юу гэж үзэж байгаа юм? Сангийн яам юу гэж үзэж байгаа юм, асуусан юм байна уу, үгүй юү? Тэгээд яг 24 онд хэдэн орон тоо төсөвтөө багтаагаад ирэх юм? Танай төсөв тийм боломжтой, төсөв хүрэлцээтэй байдаг юм уу? 25 онд хэдийг нэмэх гээд байгаа юм? Танайхан чинь тэгээд ТТ юу? Төрийн тусгайд явдаг уу ангилал? Төрийн тусгай. Тэгэхээр энэ дээр тодруулж өгөөч та нар.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулж хариулъя. Наранчимэг дарга 3 номер.

Ц.Наранчимэг: Бид эхний ээлжид аймаг бүрийн орон тоог 2 хүнээр нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа. Тэгэхээр эндээс 22 аймаг маань 44 албан хаагчийг эхний ээлжид нэмэгдүүлнэ. Нийслэл дэх Төрийн аудитын газар маань Монгол Улсын нийт төсвийн гуравны нэгийг хянаж байгаа маш том байгууллага байгаа. Нийслэлийн орон тоог бол 15 хүнээр нэмэгдүүлэхээр төлөвлөлтийн тооцоогоо хийж байна. Одоо 2025 оны төсвийн төслөө бид боловсруулж байгаа. Тийм учраас төсөв төсөвт ачаалал өгөхгүйгээр нийт дээд хязгаараа батлуулж аваад тэгээд төсөвтөө тааруулаад хийхээр 3 жилийн төсвийн тооцоолол.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн асуулт асууя. Даваасүрэн гишүүн микрофон. Өөрөө асах байх. Даваасүрэн гишүүний микрофоныг. Гэрэл нь ногоон асаад байна.

Ц.Даваасүрэн: Манай аудитынхан ч гэсэн бас өөрсдөө сайн бодмоор байна. Уг нь хөөе манайхан байж бай л даа. Та нар байна шүү дээ өнгөрсөн жил төсөв 2 дахин өсгөхөд уг нь та нар дуугарах ёстой байсан байхгүй юу. 12 их наядын төсвийг 24 болгоход та нар энэ болохгүй ээ гэж хэлэх ёстой байсан байхгүй юу.

Одоо энэ бүх орлого чинь 70, 80 хувь нь зөвхөн нүүрснээс орж байна шүү дээ. Нүүрсний 9 тэрбум доллароос орж ирж байна. Нүүрсний үнэ 2 дахин уначихвал яах юм бэ? Энэ саяын бид нарын өнгөрсөн жил нэмчихсэн 12 их наядыг хаанаас олж ирэх юм бэ?

Яагаад та нар өөрсдөө тэгж дуугарч болдоггүй юм? Тэгээд өөрсдөө орон тоогоо нэмнэ гээд ороод ирж байдаг. 54 тэрбум гэдэг чинь их мөнгө шүү дээ. Одоо би нэг зүйл дээр их айж байна. Хэрвээ нүүрсэн дээр асуудал үүсвэл бид нар ер нь яах юм бэ? Сая өсгөчихсөн, энэ 2 дахин өсгөчихсөн энэ бүх зардлыг ер нь хаанаас гаргах юм бэ? Яаж цалинжуулах юм бэ? Байхгүй шүү

дээ. Зөвхөн нүүрс байхгүй юу. Нүүрсний үнийн өсөлт.

Тэгэхээр энэ хэдүүлээ манай Байнгын хороо юу гэж үзэж байгаа юм? Яг ийм эгзэгтэй цаг үед бол шийдэх нь дэмий байж магадгүй. Тэртээ тэргүй энэний дараа тодотгол хийх юм чинь тээ. Энэ сонгуулийн үр дүнгээр шинэ Засгийн газар байгуулагдана, тодотгол хийгдэнэ. Тэгж байж ярихгүй бол одоо миний ойлгож байгаагаар бол энэ төсвийн байдал бол ирэх жилээс хүндэрнэ. Мөнгөний нийлүүлэлт байна шүү дээ 7 их наядаар нэмэгдсэн байна. Мөнгөний нийлүүлэлт өнгөрсөн жилтэйгээ харьцуулахад. Тэр 7 их наяд гэдэг чинь юу вэ. Инфляцыг бий болгоно шүү дээ одоо. Өнгөрсөн 22, 23 оны үед байна шүү дээ 2 их наядын зөрүү л гарч байсан. Мөнгөний нийлүүлэлт дээр. Одоо эхний 5 улиралд 7 их наядыг нийлүүлчихсэн байж байна шүү дээ. Энэ чинь өөрөө энэ төсөв 2 дахин өссөнтэй холбоотой. Тэгээд энэ мэтийн юмнуудаа бид нар бодож явахгүй бол пал гээд л унах л ийм байдал руу л орчих шиг болох юм. Миний ойлгож байгаагаар.

Одоо тэр их мөнгөний нийлүүлэлт, тэр их гарчихсан байгаа мөнгө чинь инфляцад нөлөөлнө, валютын ханшид нөлөөлнө. Ингээд хямралын цикл явчих вий дээ гэж би айгаад байгаа учраас цалингаа нэмэх, орон тоогоо нэмэх энэ асуудал дээр уг нь манай аудитынхан энэ тэр л энэ дээр чинь жинхэнэ мэргэжлийн байгууллагууд л та нар болохгүй ээ, ингэж нэмж болохгүй ээ гээд л ингээд л уг нь бид нарыгаа сануулж байх ёстой л баймаар л гэж би бодоод байх юм. Миний харж байгаагаар бол энэ нүүрсний үнэ дээр жосоохон асуудал үүсэхэд бид нар баларна шүү. Санхүүжүүлж чадахгүй болно. Тэгээд энэ асуудлыг нэг их яаралтай биш бол дараагийн Засгийн газар бүрэлдэхэд, төсөв тодотгоход яривал яасан юм бэ л гэж. Би зүгээр миний хувьд тийм бодолтой байна.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн санал хэллээ гэж ойлгоё тээ? Ойлголоо.

Ер нь та хэд бас их хугацаа тулгаж орж ирсэн. Чуулганы төсөв түрүүн бас орж ирж байна. Нэг талдаа бас хариуцлагагүй хандаж байна шүү. Гишүүдийг мэдээллээр бас урьдчилж хангахгүйгээр тулгаж орж ирж байгаа чинь учир дутагдалтай байна.

Ингээд ямар ч байсан өргөн барьсан учраас Байнгын хороо хэлэлцэх ёстой. Тэгээд санал хураалт явуулъя. Даваасүрэн гишүүн санал гаргаж байна.

“Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гараараа явна. Гишүүд.

Ингээд нийт санал хураалт 13-аас 4. За 5-аар дэмжигдсэнгүй гэхээр чинь чуулган руу орохгүй гэсэн үг үү? Окэй. Эргээд энэ асуудлаар ярилцацгаая.

Байнгын хорооны тогтоолын төсөл дэмжигдсэнгүй.

Асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн сүүлийн асуудал байгаа. Хот, тосгоны тухай хууль.

11.13 цаг

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 17 хууль, 1 тогтоол байгаа.

Ажлын хэсгийг гялс дуудъя, гялс санал хураалтаа явуулъя.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 17 хууль, 1 тогтоол байгаа.

Энэ хуулийн төслийг эцэслэн баталж шийдвэр гаргах нь Төрийн

байгуулалтын байнгын хорооны хуралдаад эхэлсэн учраас манай Байнгын хороогоор энэ асуудлыг хэлэлцэх шаардлагагүй болсон байна. Ийм учраас энэ асуудлыг хойшлууллаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

11.19 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР